



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 41

Улаанбаатар хот

Г “Хорол-Эрдэнэ” ХК-ийн нэгдмэл сонирхолтой 7
хувьцаа эзэмшигчдээс гаргасан саналыг
зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, Компанийн тухай хуулийн 57.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Хорол-Эрдэнэ” ХК-ийн нийт гаргасан 86,850 ширхэг энгийн хувьцааны 53.6 хувь буюу 46,548 ширхэг хувьцааг нэгдмэл сонирхолтойгоор эзэмшигчид болох иргэн Д.Эрдэнэбат, Ц.Эрдэнэчимэг нараас тус хувьцаат компанийн бусад хувьцаа эзэмшигчдийн өмчлөлд байгаа нийт хувьцааны 46.4 хувь буюу 40,302 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 100 /нэг зуу/ төгрөгөөс доошгүй үнээр худалдан авах санал гаргасныг зөвшөөрч хүчинтэй байх хугацааг 2012 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн ажлын 60 хоногоор тогтоосугай.

2. Холбогдох хууль, журмын дагуу хувьцааг худалдан авах саналаа нийтэд сурталчилж, хуулиар хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлэх, хувьцааг худалдан авах саналын хугацаа дуусмагц ажлын 5 хоногт худалдан авах саналын хэрэгжилтийн тайланг Хороонд ирүүлэхийг нэгдмэл сонирхолтой этгээд/Д.Эрдэнэбат, Ц.Эрдэнэчимэг нарт/-үүдэд үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар/Б.Саруул/-т, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар/Д.Нямцэрэн/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН